



ЭРЭЭНЦАВ ХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар
сарын 09-ний өдөр

ТУЗ-01/2026

Улаанбаатар
хот

2025 оны жилийн эцсийн Санхүүгийн тайланг хэлэлцэх, Санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэх тухай

Компанийн тухай хуулийн 75-р зүйлийн 75.1, 76-р зүйлийн 76.1.10, 76.1.11, 76.2, 96.5-р заалтууд, Эрээнцав ХК-ийн дүрэм, ТУЗ-ийн Аудитын хорооны 2026.02.09-ний өдрийн АХ-01/2026 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2025 оны жилийн эцсийн Санхүүгийн тайланг 1-р хавсралтаар баталсугай.
2. Компанийн 2025 оны жилийн эцсийн Санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар "Ай Жэй Эй Эйч Аудит" ХХК-ийг сонгосугай.
3. "Ай Жэй Эй Эйч Аудит" ХХК-тай гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захирал /М.Бат/-д зөвшөөрсүгэй.
4. 2025 оны жилийн эцсийн Санхүүгийн тайлан болон Санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын байгууллагаас хийсэн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулж хэлэлцүүлэхийг Гүйцэтгэх захирал /М.Бат/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

Ц.ЛХАГВАДОРЖ



ЭРЭЭНЦАВ ХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар
сарын 09-ны өдөр

ТУЗ-02/2026

Улаанбаатар
хот

Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй тухай

Компанийн тухай хуулийн 75-р зүйлийн 75.1, 46-р зүйлийн 46.1, 46.6, 76-р зүйлийн 76.1.12-р заалтууд болон Эрээнцав ХК-ийн дүрмийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. 2025 оны санхүүгийн жилд үйл ажиллагаа тогтворгүй байснаас шалтгаалан компани ашиггүй ажилласан тул компанийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 46-р зүйлийн 46.6-д заасны дагуу ногдол ашиг хуваарилахгүй тухай үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнах, үйл ажиллагааны тайланд тусгахыг Гүйцэтгэх захирал /М.Бат/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

Ц.ЛХАГВАДОРЖ



ЭРЭЭНЦАВ ХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 дугаар
сарын 09-ний өдөр

ТУЗ-03/2026

Улаанбаатар
хот

Эрэнцав ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59-р зүйлийн 59.4, 60-р зүйлийн 60.1, 60.2, 62-р зүйлийн 62.1, 76-р зүйлийн 76.1-р заалтууд, Эрэнцав ХК-ийн дүрмийг үндэслэн **ТОГТООХ** нь:

- Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлыг 2026 оны 04-р сарын 24-ний өдрийн 16:00 цагт хуралдуулсугай.
- Компанийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.2-ын дагуу дараах мэдээллийг баталсугай.
 - Хурал хуралдах газар:** Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо, 75/1-10 тоот Эрхэт трейд ХХК-ийн байранд;
 - Хуралдах өдөр, цаг:** 2026 оны 04-р сарын 24-ний өдрийн 16:00 цагт;
 - Хурлаар хэлэлцэх асуудлууд:** 2025 оны Үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг батлах;
2025 оны Санхүүгийн тайлангийн дүгнэлтийг батлах;
ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
Бусад;
 - Бүртгэлийн өдөр:** 2026 оны 03-р сарын 02-ны өдөр;
 - Хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр:** 2026 оны 02-р сарын 12, 2026 оны 02-р сарын 27-ны өдөр;
 - Хурлын дарга:** Ц.Лхагвадорж /ТУЗ-ийн дарга/
 - Тооллогын комиссын дарга, гишүүд** Дарга: Л.Даваа, Гишүүд: Г.Одгэрэл, Л.Ням
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, холбогдох баримт бичгийг 2026.02.10-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /М.Бат/-д даалгасугай.
- Хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах комиссыг Ц.Лхагвадорж /комиссын дарга/, Л.Даваа, М.Бат нарын бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Компанийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.4-т заасны дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслэл, компанийн цахим хуудас, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2026.02.12, 2026.02.27-ны өдрүүдэд олон нийт, хувьцаа эзэмшигчидэд хүргэхийг Гүйцэтгэх захирал /М.Бат/-д даалгасугай.
- Хувьцаа эзэмшигчдийн хурал хийх тухай мэдэгдлийг 1-р хавсралтаар баталсугай.
- Хувьцаа эзэмшигчдийн танилцах Баримт бичгийн жагсаалтыг 2-р хавсралтаар баталсугай.

8. Хурлын тухай олон нийтэд мэдээлэх зарын загварыг 3-р хавсралтаар баталсугай.
9. Компанийн Аудитын бодлогын баримт бичгийн 1.2, 9.1-р заалтууд, Компанийн засаглалын кодексийн 2025 оны тайлангийн 16-р заалтыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулах хөндлөнгийн аудиторыг сонгож ажиллахыг Аудитын хороо /Н.Баярсайхан/-нд даалгасугай.
10. Хуралтай холбоотой зардлыг санхүүжүүлэхийг ТУЗ-ийн дарга /Ц.Лхагвадорж/-д зөвшөөрсүгэй.
11. Энэхүү шийдвэрийг олон нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /М.Бат/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

Ц.ЛХАГВАДОРЖ



Эрэнцав ХК-ийн ТУЗ-ийн 2026.02.09-ний өдрийн
ТУЗ-03/2026 тоот тогтоолын 1-р хавсралт

Хувьцаа эзэмшигчдийн хурал хийх тухай мэдэгдэл

Компанийн нэр	Эрэнцав ХК
Компанийн хаяг, байршил	Дорнод аймаг, Чулуунхороот сум, 2-р баг 01 тоот Утас: 99102280
Хурал хуралдах өдөр, цаг	2026.04.24-ний өдрийн 16:00 цагт
Хурал хуралдах газрын хаяг, байршил	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо, 75/1-10 тоот, Эрхэт трейд ХХК-ийн байр
Хурлын төрөл	Ээлжит хурал
Хурал зарлагч	Төлөөлөн удирдах зөвлөл
Хуралдах шийдвэр гаргасан огноо	2026.02.09-ний өдрийн ТУЗ-ийн шийдвэр
Олон нийтэд зарлах огноо	2026.02.12, 2026.02.27-ны өдрүүд
Бүртгэлийн өдөр	2026.03.02-ны өдөр
Хурлын баримт бичгийг брокерийн компанид хүргүүлэх огноо	--
Хурлын даргын нэр	Ц.Лхагвадорж /ТУЗ-ийн дарга/
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэрс	Комиссын дарга: Л.Даваа Гишүүд: Г.Одгэрэл, Л.Ням
Баримт бичгийн жагсаалт /хавсралт/	Тогтоолын 2-р хавсралтаар баталсан
Баримт бичгийн хуудасны тоо	Нийт 32 хуудас

Хурал зохион байгуулах комиссын дарга:


Ц.ЛХАГВАДОРЖ

2026.02.09-ны өдөр

Эрэнцав ХК-ийн ТУЗ-ийн 2026.02.09-ний өдрийн

ТУЗ-03/2026 тоот тогтоолын 2-р хавсралт

Хувьцаа эзэмшигчид танилцах баримт бичгийн жагсаалт

1	2025 оны Үйл ажиллагааны тайлан, дүгнэлт	7 хуудас
2	2025 оны Санхүүгийн тайлан, дүгнэлт	8 хуудас
3	Санхүүгийн тайлангийн талаарх Аудитын дүгнэлт	15 хуудас
4	Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл Үйл ажиллагааны тайлангийн 2-р хуудсанд тодорхой тусгасан	1 хуудас
5	ТУЗ-н гишүүд, Гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал Үйл ажиллагааны тайлангийн 3-р хуудсанд тодорхой тусгасан	1 хуудас

Эрэнцав ХК-ийн ТУЗ-ийн 2026.02.09-ний өдрийн

ТУЗ-03/2026 тоот тогтоолын 3-р хавсралт

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг олон нийтэд мэдээлэх зар

Эрэнцав ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн анхааралд

Дорнод аймаг, Чулуунхороот сумын Эрэнцав ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04-р сарын 24-ний өдрийн 16:00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо, 75/1-10 тоот Эрхэт трейд ХХК-ийн байранд болно.

Бүртгэлийн өдөр: 2026 оны 03-р сарын 02-ны өдөр

Хэлэлцэх асуудлууд:

- 2025 оны Үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг батлах;
- 2025 оны Санхүүгийн тайлангийн дүгнэлтийг батлах;
- ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг тогтоох;

Хувьцаа эзэмшигчид 2026.02.12-ны өдрөөс эхлэн компанийн цахим хуудсаар болон ажлын өдрийн 09:00-17:00 цагийн хооронд компанийн байранд ирж холбогдох бичиг баримттай танилцаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо, 75/1-10 тоот, Эрхэт трейд ХХК-ийн байр

Утас: 9911-8738, 9910-2280, 9029-1789; email: bataa.mj@gmail.com

Эрэнцав ХК
Хурал зохион байгуулах комисс